



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 1/319

Улаанбаатар хот

“Нарлаг-Өндөрүүд” сууц өмчлөгчдийн  
холбоог бүртгэж, гэрчилгээ олгох  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 3 дугаар хорооны Нарны хороолол 21, 22, 23, 24, 25, 26, 27, 27а, 28 дугаар байрны оршин суугчдын бүх гишүүдийн хурлын шийдвэрээр “Нарлаг-Өндөрүүд” сууц өмчлөгчдийн холбоо байгуулсан тухай холбогдох материалыг үндэслэл болгон дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд бүртгэж, гэрчилгээг олгох ажлыг зохион байгуулсугай.

2. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах, биелэлтийг ханган ажиллахыг “Нарлаг-Өндөрүүд” сууц өмчлөгчдийн холбоонд үүрэг болгосугай.

3. Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд бүртгэх, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс Л.Мөнгөтулга-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА